



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/05/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.20 № 24

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Цахир сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшуулал 13,857.9 мянган төгрөгийг илүү олгосон.
2. Цалингийн сангаас улс төрийн албан хаагчдад 12,456.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгож, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн.
3. Тайлант онд 10,109.6 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн.
4. Төсөвт зохицуулалт хийлгүйгээр 6,946.4 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн үйл ажиллагааны зардал, түүх соёлын бусад зүйлийг хамгаалах, ажил олгогчоос олгох тэтгэмж,

урамшуулал, дэмжлэг, орон нутгийн нөөц хөрөнгө, эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа, хагас жилийн мал тооллого, улсын баяр наадам арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,175,779.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 161,709.3 мянган төгрөгийн төсөвт байгууллагын өөрийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,139,082.9 мянган төгрөгийг зарцуулж, 198,405.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн үлдэгдэл нь цас зуд бага байгаатай холбоотой эрсдэлийн сангийн нөөц хөрөнгө болон шүтээнд зарцуулахаар төлөвлөсөн 3 арга хэмжээ хэрэгжээгүйгээс түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах арга хэмжээний зардал зарцуулагдаагүй хэмнэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан 83 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 7 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ хангалтгүй хэрэгжиж аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс 74.9 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,265,724.00	157,026,373.00
33	АВЛАГА	10,875,500.00	9,069,250.00
335	Бусад авлага	10,875,500.00	9,069,250.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,875,500.00	9,069,250.00
35	БАРАА МАТЕРИАЛ	95,353,824.00	89,185,123.00
351	Түүхий эд материал	3,282,200.00	3,282,200.00
3511	Тусгай зориулалттай материал	3,282,200.00	3,282,200.00
354	Хангамжийн материал	26,311,624.00	22,842,923.00
3541	Бичиг хэргийн материал	1,511,475.00	1,919,475.00
3542	Аж ахуйн материал	24,374,249.00	20,923,448.00
3543	Сэлбэг хэрэгсэл	400,000.00	0.00
3544	Түлш, шатах тослох материал	25,900.00	0.00
356	Мал амьтад	65,760,000.00	63,060,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	32,036,400.00	58,772,000.00
363	Тэжээлийн нөөц	32,036,400.00	58,772,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,148,037,911.66	2,140,544,382.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,148,037,911.66	2,140,544,382.54
392	Биет хөрөнгө	1,914,618,633.71	1,905,017,049.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	457,718,410.00	457,718,410.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81,760,530.96)	(100,288,742.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	199,018,172.50	215,083,115.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(85,278,183.73)	(94,899,709.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	233,673,696.34	230,093,055.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(142,154,334.69)	(104,445,728.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	110,191,188.77	102,162,947.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,220,102.89)	(42,969,837.96)
39209	Зам, гүүрийн байгууламж	524,862,327.00	524,862,327.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(106,058,246.03)	(159,018,570.11)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	204,190,000.00	204,190,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	799,095,391.25	853,828,139.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	(163,860,467.85)	(196,499,670.81)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	14,141,314.00	14,141,314.00
39217	Ном	1,060,000.00	1,060,000.00
393	Биет бус хөрөнгө	233,419,277.95	235,527,333.52
39301	Програм хангамж	5,000,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,984,722.05)	(576,666.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	232,404,000.00	232,404,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,286,303,635.66	2,297,570,755.54
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,507,500.00	10,109,653.36
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,507,500.00	10,109,653.36
413	Өглөг	7,507,500.00	10,109,653.36
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	9,600,653.36
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	509,000.00
4136	Бусад өглөг	7,507,500.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	7,507,500.00	0.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,278,796,135.66	2,287,461,102.18
51	Засгийн газрын хувь оролцоо	2,278,796,135.66	2,287,461,102.18

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	445,966,870.17	445,966,870.17
51101	Өмч: - төрийн	445,966,870.17	445,966,870.17
512	Хуримтлагдсан үр дүн	1,724,379,961.87	1,733,044,928.39
5121	Өмнөх үеийн үр дүн	1,267,335,355.12	1,724,379,961.87
5122	Тайлант үеийн үр дүн	457,044,606.75	8,664,966.52
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,449,303.62	108,449,303.62
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,286,303,635.66	2,297,570,755.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,502,391,276.00	1,546,799,050.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	778,393,087.00	352,551,942.60
120	Нийтлэг татварын бус орлого	778,393,087.00	352,551,942.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	160,813,650.00	154,914,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,813,650.00	154,914,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	590,314,089.00	197,637,642.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	27,265,348.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	723,998,189.00	1,194,247,108.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,042,389.00	18,467,808.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,634,389.00	13,417,808.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	721,955,800.00	1,175,779,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	721,955,800.00	1,175,779,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,045,346,669.25	1,506,726,743.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,045,346,669.25	1,506,726,743.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,678,820.50	1,260,319,025.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,723,152.08	564,279,835.77
210101	Үндсэн цалин	277,094,294.21	379,308,933.25
210102	Нэмэгдэл	73,463,607.87	152,008,332.75
210104	Урамшуулал	28,165,250.00	32,962,569.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,183,018.81	78,758,862.36
210201	Тэтгэврийн даатгал	32,105,516.20	56,028,075.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,777,119.74	5,653,515.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,071,695.40	4,492,281.85
210204	Ажилгүйдлийн даатгал	738,944.37	1,277,957.85
210205	Эрүүл мэндийн даатгал	7,489,743.10	11,307,031.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,112,956.36	41,174,847.00
210301	Гэрэл, цахилгаан	3,549,485.00	8,294,247.00
210302	Түлш, халаалт	26,563,471.36	32,880,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,052,230.00	70,688,701.00
210401	Бичиг хэрэг	10,745,300.00	14,371,600.00
210402	Тээвэр, шатахуун	45,625,730.00	38,629,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,940,000.00	6,695,000.00
210404	Ном, хэвлэл	123,300.00	70,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,373,700.00	2,259,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,244,200.00	8,663,001.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	31,354,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		27,354,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,297,000.00	25,014,000.00
210702	Дотоод албан томилолт	12,297,000.00	25,014,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,494,223.00	99,888,149.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,765,223.00	99,708,149.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	94,688.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	0.00
210807	Газрын төлбөр	350,000.00	85,312.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,316,240.25	349,160,630.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,680,770.00	138,156,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,297,800.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,337,670.25	211,003,830.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,667,848.75	246,407,717.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	48,002,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		44,502,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	154,667,848.75	198,405,717.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	154,667,848.75	198,405,717.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	457,044,606.75	40,072,307.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	31,407,340.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	31,407,340.92
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	(31,407,340.92)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	457,044,606.75	8,664,966.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	884,811,839.00	1,355,956,408.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	160,813,650.00	161,709,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	160,813,650.00	161,709,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	160,813,650.00	161,709,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,813,650.00	161,709,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	723,998,189.00	1,194,247,108.00
311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,042,389.00	18,467,808.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,634,389.00	13,417,808.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	721,955,800.00	1,175,779,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	721,955,800.00	1,175,779,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	819,580,699.00	1,318,676,408.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	819,580,699.00	1,318,676,408.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,912,850.25	1,072,268,690.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,723,152.08	563,056,344.77
210101	Үндсэн цалин	280,384,830.76	378,085,442.25
210102	Нэмэгдэл	70,173,071.32	152,008,332.75
210104	Урамшуулал	28,165,250.00	32,962,569.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,183,018.81	70,381,700.00
210201	Тэтгэврийн даатгал	32,105,516.20	47,859,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,777,119.74	5,630,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,071,695.40	4,504,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	738,944.37	1,126,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,489,743.10	11,261,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,112,956.36	41,174,847.00
210301	Гэрэл, цахилгаан	3,549,485.00	11,182,927.00
210302	Түлш, халаалт	26,563,471.36	29,991,920.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,893,600.00	65,051,200.00
210401	Бичиг хэрэг	9,300,000.00	14,414,600.00
210402	Тээвэр, шатахуун	45,652,400.00	38,606,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,940,000.00	5,940,000.00
210404	Ном, хэвлэл	123,300.00	112,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,540,000.00	2,259,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,337,900.00	3,719,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	31,354,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	27,354,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,297,000.00	25,000,000.00
210702	Дотоод албан томилолт	12,297,000.00	25,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,981,123.00	144,964,999.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,252,123.00	144,784,999.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	94,688.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	0.00
210807	Газрын төлбөр	350,000.00	85,312.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,222,000.00	131,285,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,925,000.00	131,285,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,297,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,667,848.75	246,407,717.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	48,002,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	44,502,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	154,667,848.75	198,405,717.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	154,667,848.75	198,405,717.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	65,231,140.00	37,280,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	65,231,140.00	37,280,000.00
	Дотоод эх үүсвэрээр	65,231,140.00	37,280,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,231,140.00	37,280,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(65,231,140.00)	(37,280,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,267,335,355.12	1,821,751,528.91
2	Тайлант үеийн үр дүн	-	-	457,044,606.75	457,044,606.75
3	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,724,379,961.87	2,278,796,135.66
9	Тайлант үеийн үр дүн	-	-	8,664,966.52	8,664,966.52
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,733,044,928.39	2,287,461,102.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,320,810,100.00	1,157,550,690.77	163,259,409.23	87.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,320,810,100.00	1,157,550,690.77	163,259,409.23	87.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,272,808,100.00	1,109,548,690.77	163,259,409.23	87.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,057,300.00	563,056,344.77	955.23	100.00
210101	Үндсэн цалин	563,057,300.00	378,085,442.25	184,971,857.75	67.15
210102	Нэмэгдэл	0.00	152,008,332.75	-152,008,332.75	0.00
210104	Урамшуулал	0.00	32,962,569.77	-32,962,569.77	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,381,700.00	70,381,700.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	47,859,400.00	47,859,400.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,630,600.00	5,630,600.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,504,500.00	4,504,500.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,126,100.00	1,126,100.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,261,100.00	11,261,100.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,718,500.00	41,174,847.00	543,653.00	98.7
210301	Гэрэл, цахилгаан	11,718,500.00	11,182,927.00	535,573.00	95.43
210302	Түлш, халаалт	30,000,000.00	29,991,920.00	8,080.00	99.97
2104	Хангамж, бараа материалын зардал	63,288,800.00	65,051,200.00	-1,762,400.00	102.78
210401	Бичиг хэрэг	12,364,600.00	14,414,600.00	-2,050,000.00	116.58
210402	Тээвэр, шатахуун	38,606,200.00	38,606,200.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,940,000.00	5,940,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	218,800.00	112,000.00	106,800.00	51.19
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,259,200.00	2,259,200.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,900,000.00	3,719,200.00	180,800.00	95.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,566,100.00	61,354,000.00	212,100.00	99.66
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,566,100.00	57,354,000.00	-9,787,900.00	120.58
210602	Тавилга	10,000,000.00		10,000,000.00	
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	25,000,000.00	25,000,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	25,000,000.00	25,000,000.00	0.00	100.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	229,222,700.00	148,644,999.00	80,577,701.00	64.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,375,700.00	148,464,999.00	78,910,701.00	65.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	0.00	800,000.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	165,000.00	0.00	165,000.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	94,688.00	205,312.00	31.56
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00		132,000.00	
210807	Газрын төлбөр	450,000.00	85,312.00	364,688.00	18.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,573,000.00	134,885,600.00	83,687,400.00	61.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	218,573,000.00	134,885,600.00	83,687,400.00	61.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,002,000.00	48,002,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,002,000.00	48,002,000.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,502,000.00	44,502,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,320,810,100.00	1,157,550,690.77	163,259,409.23	87.64
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,175,779,300.00	977,373,582.77	198,405,717.23	83.13
132001	Орон нутгийн төсвөөс	1,175,779,300.00	977,373,582.77	198,405,717.23	83.13
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА С	145,030,800.00	161,709,300.00	-16,678,500.00	111.5
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,030,800.00	161,709,300.00	-16,678,500.00	111.5
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	26	0.00	100.00
6	Удирдах ажилтан	3	3	0.00	100.00
7	Гүйцэтгэх ажилтан	12	12	0.00	100.00
8	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00
9	Гэрээт ажилтан	6	6	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,467,808.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,467,808.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,467,808.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,050,000.00
210401	Бичиг хэрэг	2,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,027,508.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,027,508.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,390,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,390,300.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,467,808.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,467,808.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,417,808.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй тул санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Залруулаагүй нийт 44,156.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 14,643.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 29,512.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 44,156.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **14,859.1** мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цахир сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн Б/01, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Б/02 дугаар захирамж, сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллыг 6 албан хаагчид олгохдоо сүүлийн сарын үндсэн цалинг 6 дахин нэмэгдүүлж тооцон 10,027.4 мянган төгрөгийг илүү олгосон ба 3,830.5 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж төсөвт шилжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-т "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Тайлант онд 4 албан хаагчид албан томилолтын зардлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн тооцож нийт 786.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаалын 1-т "Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 24,000 төгрөг, аймгийн төвд 28,000 төгрөг, ... байрны зардлыг суманд 40,000 төгрөг, аймгийн төвд 90,000 төгрөг, ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант онд харилцагч байгууллагуудтай тухай бүр тооцоо нийлж, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүйгээс оны эцэст НДШ-ийн өр 9,600.6 мянга, шуудан холбооны өр 495.0 мянга, албан томилолтын өр 14.0 мянга нийт 10,109.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулж, батлагдсан төсвийг зохистой удирдан өр авлагагүй ажиллахад анхаарч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Улс төрийн албан хаагчдад 12,456.0 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгож, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн урамшууллыг цалингийн сангаас олгосон зөрчлийг таслан зогсоож, зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.3 Тайлант онд нэмэлт санхүүжилт болон үндсэн үйл ажиллагааны дансаар 6,946.4 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөө орон нутгийн тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж илүү олгосон.	1	13,857.9	1	13,857.9								
Албан томилолт илүү олгосон	1	786.0	1	786.0								
Улс төрийн албан тушаалтан цалингийн сангаас урамшуулал олгосон	1	12,456.0			1	12,456.0						
Тайлант өр төлбөр үүсгэсэн	1	10,109.7			1	10,109.7						
Зардлыг зориулалт бус зарцуулсан	1	6,946.4			1	6,946.4						
Нийт дүн	4	44,156.0	2	14,643.9	4	29,512.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн данс	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-